

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## САЙД НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 67 дугаар тэмдэглэлд:

"XII.3. Мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

3.1. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сайд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав:

3.1.1. Төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт хүргүүлэх;

3.1.2. Мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг цаашид тухай бүр Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраар дамжуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлж байх.

3.2. Төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах талаар төлөвлөгөө боловсруулж, 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Жадамбаад даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР